

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ
ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2021 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2021 оны жилийн эцсийн байдлаар (12 дугаар сарын 23-ны өдөр) иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 72 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн бөгөөд тэдгээрийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэж ажилласан байна.

Тус газарт ирсэн өргөдөл, гомдлыг ангилан авч үзвэл: өргөдөл, хүсэлт-68, гомдол 4 байна.

Хүснэгт-1

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын %
1	Ажлаас чөлөөлөгдөх тухай	20	27.47%
2	Цалинтай чөлөө хүсэх тухай	9	12.50%
3	Ажилд орох тухай	7	9.72%
4	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	6	8.33%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	8	11.11%
6	Цалин, хөлсний тухай	5	6.94%
7	Сургалтанд хамрагдах тухай	4	5.56%
8	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	4	5.56%
9	Жирэмсний амралтын тухай	4	5.56%
10	Ажлын сахилга, хариуцлагын тухай	1	1.39%
11	Цалингүй чөлөө хүсэх тухай	1	1.39%
12	Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	1	1.39%
13	Хөдөлмөр эрхлэлтийн тухай	1	1.39%
14	Ээлжийн амралтын тухай	1	1.39%
	Нийт өргөдөл, гомдлын дүн	72	100.00%

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3 “Өргөдөл, гомдлын нэгдсэн системээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх” зорилтын хүрээнд 2021 оны жилийн эцсийн зорилтот түвшинг “Шийдвэрлэлтийн дундаж хугацааг ажлын 5 хоногт багтаасан байна” гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд тус газарт 2021 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 2 хоног, 15 цаг 35 минут байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 03/5625 дугаар албан бичгийн дагуу тус газарт ирсэн өргөдөл, гомдолд дурьдсан асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх тодорхой саналгүй болно.

Харин 2021 оны 10 дугаар сарын 11, 18-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн иргэн С.Мишигээс гаргасан гомдлын дагуу тус байгууллагын удирдлага иргэдийг хүлээн авч уулзах уулзалтын хуваарийг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт 10:00-12:00 цагийн хооронд хүлээн авч уулзахаар хуваарь батлуулан газрын цахим хуудаст (www.ub-procurement.mn) байршуулан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЭНХТАЙВАН

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

С.ОЮУНЦЭЦЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Т.МӨНХ-ЭРДЭНЭ